

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар
2023 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|----------------------------------|---|---|------------------|---|--------------------------------------|---|-------------------|
| Нэг. Хувь хүний хөгжлийн бодлого | | | | | | | |
| 1 | 1.1.1.. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ. | 2.. Хүүхдийн цэцэрлэгийг Олон улсын “Эко цэцэрлэг”-ийн хүрэл, мөнгөн гэрэгэ, "Ногоон туг" өргөмжлөлийн шалгуурыг хангасан байгууллага болгон тохижуулах | 2021 - 2024 | 6.5 сая төгрөг зарцуулсан. | | Хүүхдэд ээлтэй орчны үнэлгээг хийж ажлын төлөвлөгөө боловсруулан 20 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж 13 чиглэлийн тайланг хүргүүлж, 2023 оны 02 дугаар сард олон улсын Эко цэцэрлэгийн “Мөнгөн гэрэгэ”-ний шалгуурыг ханган ажилласан. Сургалтын орчинд 4 бүлгийн дүрслэх урлагийн 4 сургалтын төвийг 1 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар стандартын дагуу тохижууллаа. Нийт 1000 гаруй дасгал даалгавар, хэрэглэгдэхүүний баяжилтийг хийсэн. Гадаа талбайд 3ш мод, 4Х38м.кв талбайд олон настын зүлэг тарьсан. 8Х3м.кв туршилтын талбайд хүнсний ногоо, 10х3 хэмжээтэй хүлэмжийг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авч суурилуулан, нарийн ногоо тарьж хураан авч хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэсэн. Гадаад дотоод орчны эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэхэд 6 сая төгрөг зарцуулсан. Хавсралт : 1 зураг | 100% |
| 2 | 1.1.2.. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон | 4.. Багш нарын мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлэх, | 2021 - 2024 | | | Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 21 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Аplus.ийн сургалтанд 6 багш 12 сэдвийн хүрээнд хамрагдаж гэрчилгээгээ авсан. А3-ийн сургалтанд 4 багш, 2 туслах багш, багшийн мэргэжил дээшлүүлэх | 100% |

| | | | | | | |
|---|--|---|-------------|--|---|------|
| | багшлах ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн "Шинэ багш", "Зочин багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн "Зочин багш", "Шинэ багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | | үндсэн сургалтанд 3 багш, Хүүхдийн хөгжлийн үнэлгээний сургалтанд 6 багш, "Алсын хараа 2050" цахим сургалтанд эрхлэгч, 6 багш, дотоодын сургалтанд 12 сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 45 багш хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Ажлын байран дээр мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ажиллах нөхцөл боломжийг 100% бүрдүүлсэн. Багш нарын ур чадварын уралдааныг 2 удаа зохион байгуулж, 10 багш хамрагдаж, заах арга ур чадвараа дээшлүүлсэн. Зочин багш хөтөлбөрийг баянхонгор аймгийн 6-р цэцэрлэгтэй хамтран зохион байгуулсан. | |
| 3 | 1.1.3.. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | 5.. Амьжиргааны түвшин доогуур өрхийн сурагчид, хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | Улсын төсөв | ЕБС-ийн 8-ын а,б ангийн 30 сурагч, 9-ийн а,б ангийн 44 сурагчид Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг 8 удаа явууллаа. Өрхийн хөгжилд хамрагдаж буй айлуудын хүүхдүүд цэцэрлэг сургуульд бүрэн хамрагдаж байна. 1-р багийн иргэн Ц. Баатаржав, 5-р багийн иргэн Х.Тэрбиш нарын хүүхдүүдийн сургалтын төлбөрийн 50%-ийг даах СЗД-ын шийд гарсан. Өрхийн хөгжилд байгаа иргэн Ц.Баатаржавын хүү Банзрагч жудо, чөлөөт бөх, Х.Тэрбишийн охин Мөнхзаяа волейболын дугуйланд хамрагдаж байна. 4-р багийн иргэн Төмөрбаатарын охин Отгонзаяа БНОХ-т хамрагдсан. Хавсралт : 1 зураг | 100% |
| 4 | 1.1.4.. Сумдын сургууль цэцэрлэг, соёлын төвүүдийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үе | 6.. Гал тогооны тоног төхөөрөмж багш нарын компьютер, ширээ сандал, зөөлөн эдлэл, сургалтын хэрэглэгдэхүүн, | 2021 - 2024 | 2743000 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. | Угаалгын өрөөнд угаалгын машин 1ш, индүү 1ш, гал тогоонд цахилгаан жин 1ш, бүлгүүдэд цонхны хөшиг, гал хамгаалах багц худалдан авч нийт 2,743,000 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|-------------|-------------|--|---|------|
| | шаттай хангана. | хүүхдийн тоглоомны хангалтыг хийнэ. | | | | | |
| 5 | | 7.. Бага сургуулийн дотоод тохижилтыг бүрэн хийх | 2022 - 2024 | Улсын төсөв | | Гурванбулаг сумын төвд баригдаж буй 160 хүүхдийн барилгын явцын мэдээлэл. Хүчин чадал : хоёр давхар 160 хүүхдийн суудалтай Хэмжээ 17х37 метр Зургийн автар: Баяндизайн ХХК Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: Гурванбулаг сод ХХК Захиалагчийн хяналтын байгууллага: Баянхонгор аймаг Газрын харилцаа Бага сургуулийн дотоод тохижилт 100%-ийн гүйцэтгэлтэй Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. | 100% |
| 6 | 1.1.5.. Анги дэвших, төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно. | 8.. Хичээл - Үр дүн" аяныг зохион байгуулж хичээлийн хөтөлбөр төлөвлөлт арга зүйн боловсруулалт, багшийн өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээ, анги төгсөх дэвших шалгалтын дүнгийн дундажаар багш нарыг дүгнэж шалгаруулах | 2021 - 2024 | Улсын төсөв | | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 бүлгийн 64 ажил төлөвлөснөөс 97.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Суурь боловсрол эзэмжих улсын шалгалтыг 5 дугаар сарын 29-өөс 6 дугаар сарын 08 хүртэл захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж авч 100 %ийн амжилттай төгсгөв. Амжилт 82.84%, Чанар 39.1% Дэвших шалгалт Чанар 34.1, амжилт 100%-тай шалгагдлаа. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 24 багшаас 17 багш 1-4 түвшинд үнэлэгдэн урамшуулалд хамрагдсан. Гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтанд 61.6%-тай үнэлэгдэж аймгийн хэмжээнд 3-т эрэмбэлэгдэв. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дунджаар 76.9%-тай үнэлэгдсэн байна .Аймгийн дунджаас 0.3%-иар дээгүүр үнэлэгдэв. | 100% |
| 7 | 1.1.6.. Сургуулийн өмнөх болон бага | 9.. "Цэцэрлэгийн насны хүүхдийн | 2021 - | | | 4 бүлгийн 111 хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх олон талт сургалтыг тогтмол зохион байгуулдаг. нийтдээ суралцахуйн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|-------------|---------|--|---|------|
| | боловсролын системд хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх олон талт сургалтыг нэвтрүүлж, хөгжүүлнэ. | сэтгэхүй хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлэх | 2024 | | | 6 чиглэлээр 885 сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэн хүүхдүүдээр ажиллуулан сэтгэхүйг нь хөгжүүлж байна. Бэлтгэл бүлгийн 39 хүүхэд даам тоглож сурсан. Өрж байгуулах, эвлүүлэх тоглоомоор хүүхдийг тогтмол тоглуулж бүтээлч сэтгэхүйг хөгжүүлсэн ба хүүхдийн IQ хөгжүүлэх, спорт өрөлтийн дасгалуудыг дугуйлангаар ажиллуулсан. | |
| 8 | 1.2.1.. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдийг жил бүр нэг удаа урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг | 10.. Сумд оршин суугаа 15-65 насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 300000 | | Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэгт Артерийн гипертензи-700 хүн, чихрийн шижин - 500 хүн, хөх умайн хүзүүний эрт илрүүлэгт -135 хүн хамрагдахаас артерийн гипертензи-174 чихрийн шижин - 167 хүн хөх умайн хүзүүний эрт илрүүлэг-101 хүн, элэгний В,С илрүүлэгт -56 хүн хамрагдсан байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна. Эрт илрүүлэг үзлэгт иргэдийн 20% хамрагдсан. Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор нэг талын зардлыг дааж 2 удаа Баянхонгор аймаг руу тээвэрлэж эрт илрүүлэг үзлэгт 62 хүнийг хамруулсан. Хавсралт : 2 зураг | 90% |
| 9 | дараагийн шатны үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ. | 11.. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулах. | 2021 - 2024 | 1600000 | | Нийгмийн эрүүл мэндийн ажилтны чадавхжуулах сургалтанд БХ аймагт эрүүл мэндийн газарт хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Сумын иргэдэд нийт 31 удаа сургалт явуулж давхардсан тоогоор 1573 хүн хамрагдсан. Зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөний биелэлтээ улирлаар нь гаргаж үр дүнг тооцон ажилласан. Календарчилсан төлөвлөгөөний дагуу | 100% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|--|---|-----|
| | | | | | <p>Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг хуваарийн дагуу эмч ажилчидтай хамтран зохион байгуулсан. Нийт 16-н дэлхийн тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн. "Хүүхэд аюулгүй орчин" сэдэвт унаж, бэртэхээс урьдчилан сэргийлэх аяны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажилласан. Сумын эмэгтэйчүүдийн дунд Аз жаргалтай эмэгтэйчүүд 2023 нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдсан. Нэг хамт олон-нэг сайн дурын ажил дээр байрны хүүхдүүдийг шүдний эмчид үзүүлэн оношлуулж эмчлүүлэх тал хамтарч ажилласан. "Энэ жилдээ эрүүл жиндээ" аян, эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний хүрээнд дасгал хөдөлгөөний үйл ажиллагаа, сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрт аян, ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын аян, халдварт хэлбэрийн сүрьеэгээс урьдчилан сэргийлэх аян, ээлтэй орчин-эвсэг хамт олон аян, оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эдгээрийг зохион байгуулж ажилласан байна.</p> <p>Хавсралт : 19 зураг</p> | |
| 10 | 1.2.2.. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, резидент сургалтанд хамруулах, салбарын удирдлагын менежментийг | 12.. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудаас жилд 2 хүнийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах. | 2021 - 2024 | Улсын төсвөөр, Эрүүл мэндийн төвөөс нийгмийн баталгааг хангаж цалинтай сургасан. | <p>Сумын эрүүл мэндийн төвөөс вакциначторын олгох курст 3 сарын хугацаатай 1 хүнийг сурган, ажиллуулж байна. Эрүүл мэндийн төвд 90 хувь мэргэжлийн боловсон хүчин ажиллаж байна.</p> | 90% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|---|--|------|
| | сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | |
| 11 | 1.2.3.. Эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна. | 13.. Эрүүл мэндийн төв шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх бодис оношлуурын нөөцийг тухай бүр бүрдүүлж ажиллах. | 2021 - 2024 | 25 сая төгрөгийн татан авалт хийсэн. | Энэ онд хамгаалах хэрэгсэл, урвалж тест, эм эмнэлгийн хэрэгсэл 2 сарын нөөцтэй байна. Түргэвчилсэн тест 500ш, элэгний В, С 150, ХДХВ ДОХ-150, шээсний тест 200, хеликобактери 100 ширхэгийн нөөцтэй байна. | 100% |
| 12 | 1.2.5.. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 14.. Эм эмнэлгийн хэрэгслийн шаардлагатай нөөц нэр төрлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах. | 2021 - 2024 | Нийт 16 удаагийн татан авалтаар 42 сая төгрөгний эм эмнэлгийн хэрэгсэлээр хангасан. | Зайлшгүй шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг өмнөх оноос 24 -өөр нэмэгдүүлсэн. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 90%-тай байна. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөц 1-3 сарын нөөцтэй байна. Новартс хөтөлбөрт хамрагдаж эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хөнгөлөгдөх 8 нэр төрлийн эмийг татан авч сумын иргэдэд үнэ төлбөргүй олгож байна. | 100% |
| 13 | 1.3.1.. Нийтийн биеийн тамирыг олны хүртээл болгох, энэ чиглэлээр санаачилга гаргасан иргэн, гэр | 15.. "Эрүүл амьдрал-Идэвхтэй хөдөлгөөн" аяныг зарлаж, ажлын байрны дасгал хийж хэвшил | 2021 - 2024 | 420000 | Эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, илүүдэл жинг тодорхойлох, дасгал хөдөлгөөн, өглөөний цайнаас эрүүл мэнд эхлэнэ зэрэг сэдэвт сургалтыг албан байгууллагуудад 2 удаа явуулсан. Үүнээс ЕБС-ийн багш ажилтан- 30, Цэцэрлэгийн-12 ажилтан, ЗДТГ-16 ажилтан Соёлын төв-3 ажилтан, эрүүл мэндийн төвийн -23 ажилтан хамрагдсан нийт төрийн албан хаагч 84 хүн сургалтанд хамрагдсан | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|---|---|------|
| | бүл, баг, байгууллага хамт олныг дэмжих. | болгосон байгууллага, хамт олныг дэмжих, урамшуулах | | | байна. Мөн 150-н иргэн сургалтанд хамрагдсан. Биеийн тамирын арга зүйч Эрдэнэ-Очиртой хамтран 7 хоногт 1 удаа төрийн 4-н байгууллагын ажилчид дасгал хөдөлгөөнд хамрагддаг. Ахмадуудад зааланд 3 удаа дасгал хөдөлгөөнд хамрагддаг. Залуус 7 хоногт 2 удаа дасгал хөдөлгөөнд хамрагдаж байна. 5-сарын 15-наас 6-р сарын 15-ныг хүртэл нарны алхалтанд нэгдэх удирдамж гарган иргэдийг 7 хоногт даваа, лхагва гарагийн өглөөний 7 цагт тогтмол нарны алхалтанд хамруулсан. Алхсан өдрийнхөө зургийг тухайн өдөртөө сумынхаа эрүүл мэндийн фэйсбүүк хуудсанд тогтмол байршуулсан. Нарны алхалтанд албан байгууллага, ахмадууд, залуус идэвхтэй хамрагдсан. Нийт 40-н хүн хамрагдсан. Хүүхдийн цэцэрлэгийн хамт олон 10 удаа 100%-ийн ирцтэй, нэмэлтээр 12 удаа 90-100%-ийн ирцтэй хамрагдсан. Ажлын байран дээрээ түмэн дасгалыг бүх албан хаагч өдөр бүр хийж хэвшсэн. Бусад байгууллага манлайлан тэргүүлсэн “Хүүхдийн цэцэрлэг”-ийн хамт олон 1-р байранд шалгарсан. Иргэдээс хамгийн идэвхтэй 9-н иргэн байсан. Үүнээс Н.Ганбаатар 10 удаа 100% ирцтэй алхаж 1-р байр, С.Чулуунцэцэг 9 удаа 90% ирцтэй алхаж 2-р байр, Ж.Оюун 8 удаа 80% ирцтэй алхаж 3-р байранд тус тус шалгарсан. Аяны хүрээнд иргэн Л.Ачмаа иогийн сургалт 3-12 сар хүртэл хичээллүүлж, давхардсан тоогоор 21 иргэнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хоололт дасгал хөдөлгөөнийг хэвшүүлснээр иргэд 3-15 кг жин хаяж эрүүлжсэн байна. | |
| 14 | | 16.. Бий биелгээг сумын брэнд ажил болгон хэрэгжүүлж, соёлын биет бус | 2021 - 2024 | байгууллагын төсвөөс 200.000төгрөг зарцуулхаар төлөвлөсөн | Сумын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн анги тус бүр бий биелэгээг 3 дугаар цагийн завсарлгаанаар хийж хэвшсэн байгаа бөгөөд анги тус бүрээс монгол бүжиг бий биелэгээний хамтлаг гарсан байна. түүнчлэн соёлын төвийн бүжгийн дугуйлангаар дамжуулан хүүхдүүдийг бий | 100% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|--------|--|-----|
| | | өвийг түгээн дэлгэрүүлэх. | | байна. | биелэгээг сурталчилан таниулсан бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн багш,ажилчид, цэнгэл цэцэрлэгийн багш ажилчид соёлын төвийн ажилчид,ахмадын хороо зэрэг байгууллагуудаас тус бүр бүжгийн хамтлаг гарч бүсийн тэмцээний тэргүүн байрыг хүртсэн.1000 малчдын урлагийн наадмаас бий биелэгээн төрөлд Э.Сайн-Өлзий тэргүүн байр эзэлсэн амжилттай нийт бий биелэгээг сумын хүн амын 20% хүргэж 8 хамтлагтай байна Хавсралт : 16 зураг | |
| 15 | 1.3.2.. Олон улс, тив дэлхийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш, дагалжуулагч, тамирчдыг урамшуулах урамшууллын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ | 17.. "Олон улс, тив дэлхийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш, дагалжуулагч, тамирчдыг дэмжих, урамшуулах журам"-ыг боловсруулан хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | 700000 | Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 сарын 30-ны өдрийн 7/06 дугаар тогтоолоор “Тив дэлхий болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ыг баталсан. 2023 онд уг журамын дагуу болзол хангасан 9 хүүхдэд ЗДТГ-аас мөнгөн 700000 төгрөгний мөнгөн урамшуулал олгосон. | 90% |
| 16 | 1.4.1.. Урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлуулан өвлүүлэхийг бодлогоор | 19.. "Сахиуст хангайн нүүдэлчид" аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохиог байгуулах | 2023 | | НҮҮДЭЛЧДИЙН ӨВ СОЁЛЫГ СУРТАЛЧИЛАХ ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан “САХИУСТ ХАНГАЙН НҮҮДЭЛЧИД” ӨВ, СОЁЛЫН НААДАМ зохион байгуулах удирдамж,хөтөлбөрийг боловсруулан зохион байгуулагдах өдөр товлогдсон боловч санхүүгийн боломжоос болж түр хүлээгдээд байна. | 50% |

| | | | | | | |
|----|---|--|-------------|--------------------------------------|---|------|
| | дэмжинэ. | | | | Хавсралт : 1 файл | |
| 17 | 1.4.2.. Малчид, төрийн албан хаагчдын “Урлаг спортын наадам”-ыг 2 жилд нэг удаа зохион байгуулах. | 20.. Малчид, төрийн албан хаагчдын “Урлаг спортын наадам”-ыг 2 жилд нэг удаа зохион байгуулах. | 2021 - 2024 | үйлдвэрчний эвлэлээс | <p>- Төрийн албан хаагчдын урлаг, спортын бага наадмыг 2023 оны 04-р сарын 13-с 15 ны өдрүүдэд зохион байгуулж, Сумын ИТХ, ЗДТГ, Сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний бүх албан хаагчид, хэсгийн төлөөлөгч, Цагдаа, олон нийтийн байцаагч зэрэг төрийн тусгай албан хаагчид, Төрийн банк, Хаан банк, ШТС-ууд, Цагуурын ажилтнууд зэрэг албан хаагчид хамрагдсан. - Спортын арга хэмжээ Волейбол (эр, эм), Софт волейбол, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, гүйлт (100м эр эм, 300м эр эм, 1000м эр эм), Буухиа тэмцээн, Шатар, 100 буудалт даам, одон бөмбөгийн тэмцээн гэсэн 8 төрлөөр зохион байгуулагдаж 130 гаруй тамирчид оролцсон - Малчдын зөвлөгөөн 2023 арга хэмжээг 2023 оны 02-р сарын 12, 13-ны өдрүүдэд ЗДТГ санаачлан зохион байгуулсан. Зөвлөгөөний хүрээнд малчид, ард иргэдийг идэвхжүүлэх зорилгоор малчдын дунд Спортын 8 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Тэмцээний төрөл: Волейбол, софт волейбол, Шагай няслах, шагай шүүрэх, Морь уралдуулах, Алаг мэлхий өрөх, шатар, Үндэсний бөхийн барилдаан. - Уг арга хэмжээнд давхардсан тоогоор 220 малчин оролцсон. Багийн дүнгээр 1-р байранд Давааны ам 2-р баг, 2-р байранд Цэнгэл 1-р баг, 3-р байранд Буга 3-р баг, 4-р байранд Хөвийн ам баг, 5-р байранд Пионер толгой баг орсон.</p> <p>Хавсралт : 9 зураг</p> | 100% |
| 18 | 1.4.3.. Соёлын төвийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож | 21.. Соёлын төвийн үйл ажиллагаанд идэвхтэй | 2021 - 2024 | байгууллагын төсөвөөс 200.000 төгрөг | Соёлын төвийн арга хэмжээнд оролцогсодын улс аймгийн уралдаан тэмцээнд амжилттай оролцсон иргэдийг урамшуулах ажлыг хамтын гэрээнд тусган 7 иргэнийг | 90% |

| | | | | | | | |
|----|--|---|-------------|---|--|--|------|
| | буй иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгоно. | оролцсон иргэдийг урамшуулах журмыг боловсруулан хэрэгжүүлэх. | | зарцуулсан | | урамшуулад байна. | |
| 19 | 1.4.4.. Малчид, иргэдийн дунд ажил мэргэжлийн уралдааныг жил бүр зохион байгуулна. | 22.. Малчид, иргэдийн дунд ажил мэргэжлийн уралдааныг жил бүр зохион байгуулна. | 2021 - 2024 | | | Малчидын урлаг спортын бага наадмаар жолооч нарын ур чадварын уралдааныг зохион байгуулсан | 30% |
| 20 | 1.4.5.. Соёл урлагийн арга хэмжээний чанарыг сайжруулан, давтамжийг нэмэгдүүлж, сумын төвд сард 3-аас доошгүй удаа, хөдөөгийн баг тус бүрт жилд 2-оос доошгүй удаа соёл урлагийн үйлчилгээг үзүүлнэ. | 23.. Соёл урлагийн арга хэмжээний чанарыг сайжруулан, давтамжийг нэмэгдүүлж, сумын төвд сард 3-аас доошгүй удаа, хөдөөгийн баг тус бүрт жилд 2-оос доошгүй удаа соёл урлагийн үйлчилгээг үзүүлнэ. | 2021 - 2024 | нийт улсын төсвөөс 1.500.000 төгрөгийг зарцуулсан | | 2023 онд 9 удаагийн бүрэн хэмжээний тоглолт, гаднаас ирсэн тоглолт 6, зохион байгуулсан уралдаан тэмцээн 29, өргөн дэлэгцийн кино 7, бусад үйл ажиллагаа 72 нийт 124 удаагийн арга хэмжээг цахим болон танхимаар зохион байгуулж давхардсан тоогоор нийт 17052 хүнд хүрч үйлчилсэн байна. Мөн бүжгийн дугуйланг жилийн турш хичээллүүлж 31-н төрлийн бүжгийг давхардсан тоогоор 1146 хүүхдэд зааж сургасан бол хөгжмийн дугуйланд давхардсан тоогоор 160хүүхэд хамрагдсан. Баянхонгор аймгийн 1000 малчдын зөвлөгөөнд 18 хүний бүрэлдэхүүнтэй оролцож бий билэгээний төрөлд тэргүүн байр,ерөөл магтаалын төрөлд тэргүүн байр, ан ав урин дуудах төрөлд дэд байр эзлэж багийн дүнгээр шилдэг 5 т багтсан амжилттай оролцсон. Хавсралт : 20 зураг | 100% |
| 21 | 1.4.6.. Явуулын номын сангийн үйлчилгээг | 24.. Багуудад явуулын номын санг ажиллуулж, | 2021 - 2024 | байгууллагын төсвөөс 100.000 | | Нүүдлийн номын сангийн үйлчилгээг 5 багийн идэвхтэн уншигчид болон явуулын үйлчилгээгээр дамжуулан хүргэж байна. Хөвийн ам 4 дүгээр багт 87 номоор 211 уншигч, Буга | 90% |

| | | | | | | | |
|--|--|---|-------------|--------------------------|--|--|-----|
| | сайжруулж, сумын нийт өрхийн 50-иас доошгүй хувьд хүрч үйлчилнэ. | баг тус бүрээс шилдэг уншигч шалгаруулж, урамшуулах.. | | төгрөг зарцуулсан байна. | | 3-р багт 50 номоор 198 уншигчдад, Пионер толгой 5-р багт 326 уншигч. 206 ном, Давааны ам 2-р багт 92 уншигч, 147 ном, Цэнгэл 1 багт 212 уншигч 89 нийт 1039 уншигчдад 579 ном, 27 сэтгүүлээр хүүхэд, залуучууд ард иргэд болон насанд хүрэгч уншигчдад үйлчилсэн ба сумын нийт иргэдийн 50 % -д хүрч үйлчилсэн. Хөвийн ам 4 дүгээр багийн иргэн Р.Оюунцэцэг, С. Анужин, Цэнгэл 1 дүгээр баг Я.Балжирмаа, Давааны ам 2 дугаар багийн иргэн өндөр настан Д.Долгорсүрэн нар ном уншлагаар тэргүүлж “Тэргүүний уншигч” Д.НАЦАГДОРЖ тэмдэгээр шагнагдсан. | |
| 22 | 1.4.7.. Сумын “Орон нутаг судлах” танхимыг стандартын дагуу тохижуулж, үзмэрээр баяжуулан, ард иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулна. | 25.. Сумын “Орон нутаг судлах” танхимын тохижилтыг сайжруулж, ард иргэдэд сурталчилах, мэдээлэх | 2021 - 2024 | 0 | | Байгууллагын албан албан хаагчдын нөөц боломжинд тулгуурлан тохижуулж 2 үзмэрээр баяжуулан ард иргэд хүүхэд багачуудад сурталчилан таниулсан бөгөөд нийт давхардсан тоогоор 322 хүнд үйлчилсэн байна.Орон нутаг судлах танхимыг тохижуулж өрөгтгөх ажлын судалгааг гаргаж орон нутагын хөгжлийн санд хүргүүлсэн боловч дэмжэгдээгүй төсөв холбоотойгоор түр хүлээгдээд байна Хавсралт : 6 зураг | 70% |
| Хоёр. Амьдралын чанарыг сайжруулах бодлого | | | | | | | |
| 23 | 2.1.1.. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж сумын онцлог, нөөцөд тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг | 26.. Сүү цагаан идээг орчин үеийн технологээр боловсруулах жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ | 2021 - 2024 | 10 сая төгрөг | | 2022 онд Улсын төсвөөс үрлэн ааруул хэвлэгч, сүү бэлтгэх тогоо, сүү ариутгагч, ааруул хатаагч, нунтаглагч тээрэм, холигч, савлагч, цөцгий цохих машин зэрэг 44495000 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Одоогоор олгогдоогүй байна Давааны ам багийн саальчин Д.Оюунцэцэг нь Сүү цагаан идээ боловсруулах төсөл бичин сум хөгжүүлэх сангаас 10 сая төгрөгийн зээл авч сүү хөөрүүлдэг тогоо, ааруул хатаагч, аарц шахагч, аарц нунтаглагч, ааруул хэвлэгч зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаагаа явуулж байна. Хаяг, | 70% |

| | | | | | | | |
|----|--|--|-------------|---------|--|--|-----|
| | хөгжүүлнэ. | | | | | шошго, савлагааны асуудлыг шийдвэрлэсэн, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэн ажиллаж байна. | |
| 24 | 2.1.2.. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын | 27.. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллах | 2021 - 2024 | 0 | | Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд 4-р багийн иргэн Р. Оюунгэрэл хэрчсэн гурил 2-р багийн Ж. Баярсайхан дугуй засварын өргөтгөл зэрэг төсөл бичиж ирүүлсэн | 30% |
| 25 | дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ. | 28.. Арьс нэхий боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтмолжуулах | 2022 - 2024 | 0 | | Арьс нэхий үйлдвэрлэх тоног төхөөрөмж байр байгаа боловч ашиглагдахгүй байсныг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр дутуу байсан төхөөрөмжүүдийг авахуулахаар шийдүүлсэн | 30% |
| 26 | 2.1.3.. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд иргэдийг хамруулна. | 29.. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд 15-аас доошгүй иргэнийг хамруулах | 2021 - 2024 | 1-сая | | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд Ч. Жамсранжав 1-сая төгрөгийн сургалт 3-р багийн иргэн Д.Жаргалсайхан хоршооны сургагч багшийн сургалт Халзан хангайн хишиг хоршооны дарга Ц.Гантөмөр арьс ширний холбооноос зохион байгуулсан сургалтанд тус тус хамрагдсан | 50% |
| 27 | 2.1.4.. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан иргэн, бүлэг, ААН- | 30.. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан иргэн, бүлэг, | 2021 - 2024 | 1500000 | | Б.Мөнгөнжигүүр эзэнтэй Тэгшбуянт дэлгүүр 1 хүн Д. Энхээ эзэнтэй оёдлын газар 2 хүн Түр хугацаанд Г.Гантулга эзэнтэй Өндөр Жаргалант хайрхан 5 хүнийг Халзан хангайн хишиг хоршоо 5 хүнийг 11-н сард ажилуулсан байна | 50% |

| | | | | | | | |
|----|---|---|-------------|----------|--|--|-----|
| | үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно. | ААН-үүдийг жил бүр шалгаруулж урамшуулна | | | | | |
| 28 | 2.1.5.. Сумд байгуулагдсан арьс, нэхий элдэх үйлдвэрийн үйл ажиллагааг | 31.. Арьс, нэхий элдэх үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэн байнгын ажиллагаатай болгох | 2021 - 2024 | 0 | | Арьс нэхий үйлдвэрлэх тоног төхөөрөмж байр байгаа боловч ашиглагдахгүй байсныг аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөр дутуу байсан төхөөрөмжүүдийг авхуулхаар шийдүүлсэн | 30% |
| 29 | эхлүүлэн цагаан идээг уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулах, үйлдвэрлэх иргэн хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ. | 32.. Сумын нэрийн бүтээгдэхүүнтэй болж борлуулалтанд гаргах | 2021 - 2024 | 10-н сая | | Давааны ам багийн саальчин Д.Оюунцэцэг нь Сүү цагаан идээ боловсруулах төсөл бичин СХС-аас 10 сая төгрөгийн зээл авч сүү хөөрүүлдэг тогоо, ааруул хатаагч, аарц шахагч, аарц нунтаглагч, ааруул хэвлэгч зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаагаа явуулж байна. Хаяг, шошго, савлагааны асуудлыг шийдвэрлэсэн, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх боломж бүрдэж байна Мөн 5-р багийн иргэн Ц.Гомбосүрэн гар урлалын бүтээгдэхүүн хийж байна Мөн 3-р багийн саалчин П. Цэрэнтогтох цагаан идээний үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож байна | 70% |
| 30 | 2.1.6.. Сумын зах зээлийн судалгааг гаргаж жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй болон шинээр үйл ажиллагаа эхлүүлэх иргэн | 33.. Сумын зах зээлийн судалгааг гаргаж жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй болон шинээр үйл | 2021 - 2024 | 0 | | Халзан хангайн хишиг хоршоо үйл ажиллагаагаа өрөгжүүлэхээр 22 сая төгрөгийн төсөл бичиж ирүүлсэн хэлэлцэх шатанд байна Мөн 4-р багийн иргэн Р.Оюунгэрэл хэрчсэн гурил үйлдвэрлэх төсөл ирүүлсэн. | 50% |

| | | | | | | | |
|----|---|---|-------------|----------|--|---|------|
| | хуулийн этгээдийг хөрөнгө санхүү болон төрийн бодлогоор дэмжин ажиллана. | ажиллагаа эхлүүлэх иргэн хуулийн этгээдийг хөрөнгө санхүү болон төрийн бодлогоор дэмжин ажиллана. | | | | | |
| 31 | 2.2.1.. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвхи санаачилга, боломжийг дэмжиж , хөгжүүлнэ. | 34.. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэх | 2021 - 2024 | 8640000 | | Сумын хэмнээнд 13 Өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч сар бүр 720 мянган төгрөгийн үнэгүй хүнс авч байна. Зорилтод бүлгийг тодорхойлох зорилгоор 13 өрхөөс орлогыг орлуулан тооцох аргаар дахин үнэлгээнд хамруулан ажилласан мөн зорилтод бүлгийн амжиргааг дэмжих зорилгоор жил бүр 15 өрхийг сонгон авч нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж байна. | 100% |
| 32 | 2.2.2.. Төрийн захиргааны болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулах ажлыг эрчимжүүлнэ. | 35.. Төрөл бүрийн төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулах ажлыг эрчимжүүлэх | 2021 - 2024 | 25000000 | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2023 онд 5 залуу малчин өрхийг тус бүр 5 сая төгрөгөөр мал худалдан авч өгч нийт 25 сая төгрөгийн малжуулах төсөл хөтөлбөрт хамруулсан. малжуулах арга хэмжээг сумын Засаг даргын захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | |
|----|--|--|-------------|---|---|------|
| 33 | 2.2.3.. Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тэднийг бүх талаар дэмжиж ажиллана. | 36.. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2021 - 2024 | сургалт мэдээлэл хийсэн зардалд 300.000 төгрөгийг засаг даргын тамгийн газрын шатхууны зардлаас зарцууллаа. | <p>Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааг эрчижүүлэх үүднээс 10 сард нийт залуусын чуулганыг зохион байгуулж Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн тэргүүлэгч гишүүдийг шинээр сонгон тэргүүнийг сонголоо. шинээр сонгогдсон тэргүүн Ч.Жамсрандорж нарийн бичгийн дарга Б.Баярмаа нар нийт залуучуудын сэтгэгдэлийг сонсож тулгамдсан асуудлаа тодорхойлж цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөлөө. Чуулганд Баянхонгор аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Мэндбаяр болон мэргэжилтнүүдийн хамт Гэр бүл төлөвлөлтийн 8-н модуль сургалтыг зохион байгууллаа сургалтад 285 иргэн хамрагдаж мэргэжилтнүүдийг урин гэр бүлийн харилцаа болон төлөвлөлтийн талаар сургалт мэдээлэл хийлээ. Чуулганд 18-35 насны 141 залуучууд хамрагдаж залуучуудын хөгжилд тулгарсан бэрхшээлийн талаар хэлэлцэж гэр бүлийн боловсролын талаарх хууль тогтоол шийдвэртэй танилцаж мэдлэг боловсролоо дээшлүүлээ.</p> <p>Хавсралт : 3 зураг</p> | 100% |
| 34 | | 37.. Хөгжсөн 100 гэр бүл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | хөтөлбөр ИТХ аар хэлэцүүлхээр хүлээгдэж байна. | 30% |
| 35 | | 37.. Залуучуудын зөвлөгөөн зохион байгуулах. | 2021 - 2024 | сургалт мэдээлэл хийсэн зардалд | Залуучын зөвлөлийн үйл ажиллагааг эрчижүүлэх үүднээс 10 сард нийт залуусын чуулганыг зохион байгуулж Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн тэргүүлэгч гишүүдийг шинээр сонгон тэргүүнийг | 100% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|---|--|------|
| | | | | 300.000 төгрөгийг засаг даргын тамгийн газрын шатхууны зардлаас зарцууллаа. | сонголоо. шинээр сонгогдсон тэргүүн Ч.Жамсрандорж нарийн бичгийн дарга Б.Баярмаа нар нийт залуучуудын сэтгэгдэлийг сонсож тулгамдсан асуудлаа тодорхойлж цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөлөө. Чуулганд Баянхонгор аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Мэндбаяр болон мэргэжилтнүүдийн хамт Гэр бүл төлөвлөлтийн 8-н модуль сургалтыг зохион байгууллаа сургалтад 285 иргэн хамрагдаж мэргэжилтнүүдийг урин гэр бүлийн харилцаа болон төлөвлөлтийн талаар сургалт мэдээлэл хийлээ. Чуулганд 18-35 насны 141 залуучууд хамрагдаж залуучуудын хөгжилд тулгарсан бэрхшээлийн талаар хэлэлцэж гэр бүлийн боловсролын талаарх хууль тогтоол шийдвэртэй танилцэж мэдлэг боловсролоо дээшлүүллээ. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 68 хүүхдэд өсвөр насны бэлгийн боловсрол, гэр бүл төлөвлөлт зэрэг сургалт мэдээлэл хийсэн байна. Эрүүл мэндийн төвийн эх баригч сумын төрөх насны 609 эмэгтэйгийн судалгааг гаргаж хаяган дээрээ 510 эмэгтэй байгаагаас бүх төрөх насны эмэгтэйчүүдтэй холбоо тогтоон нэрийн хяналтаар хянаж ажиллаж байна. "Жирэмсний хяналтад эрт орохын ач холбогдол", "Гэр бүл төлөвлөлт", "Бэлгийн замаар дамжих халдвар" гэсэн сэдвүүдээр нийт залуу гэр бүлүүдэд мэдээлэл хийлээ. Тус чуулганы хүрээнд 18-34 насны залуусын дунд спортын 4 төрлийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Хавсралт нийт : 9 Файл : 2 Зураг : 7 | |
| 36 | 2.2.4.. Сумын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлж, нийгмийн зорилтот | 38.. Хүүхэд гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж гэр бүл хүүхдийн | 2021 - 2024 | сургалт мэдээлэл хийсэн зардалд 300.000 | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор "Цэцэгсийн түүчээ" клубыг байгуулах бүсгүйчүүдэд эерэг нөлөөллийг бий болгон 4 удаагийн уулзалт арга хэмжээг зохион байгуулж, Баянхонгор аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын газрын | 100% |

| | | | | | | |
|------------------------------|---|--|-------------|---|--|------|
| | бүлэгт хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | | төгрөгийг засаг даргын тамгийн газрын шатхууны зардлаас зарцууллаа. | мэргэжилтүүдийн хамт хөдөөгийн 25 залуу гэр бүлд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Эмэгтэйчүүдийн манлайлал", "Гэр бүлийн харилцаанд-миний оролцоо" "Гэр бүл төлөвлөлт" зэрэг сэдвүүдээр лекц, хэлэлцүүлэг зохион байгуулж давхардсан тоогоор 285 иргэн оролцлоо. Сумын цагдаатай хамтран төрийн албан хаагчдад "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар сургалт 2 удаа зохион байгуулж 208 албан хаагч хамрагдлаа. Сургалт мэдээллийн үр дүнд гэмт хэрэг гэр бүлийн хүчирхийлэл 30% иар буурч 4, гэмт хэрэг өмнөх онтой адил 4 хэрэг, зөрчил 55 бүртгэгдэж бэлэн торгуул 7.600.000 төгрөг төвлөрсөн байна. | |
| 37 | 2.2.5.. Нийгмийн даатгалын сургалт сурталчилгааг малчид, иргэдийн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмжид хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулна. | 39.. Малчид иргэдэд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мэдээлэх, сурталчилах замаар сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 152 иргэн/даатгуулагч/ хамруулж 95 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. Эрүүл мэндийн даатгалыг 249 иргэн төлж 18 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Нийгмийн даатгал,эрүүл мэндийн даатгал нь бүрэн цахимжсан. Е-баримтаар эрүүл мэндийн даатгалыг төлж байна. 2024 оны 1сарын 1ээс малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 50хувийг төрөөс хариуцах тул шимтгэл төлөлтөнд малчдын 50аас дээш хувийг хамруулахаар багийн дарга нартай хамтран ажиллахаар төлөвлөж байна | 100% |
| Гурав. Эдийн засгийн бодлого | | | | | | |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--------------|---|------|
| 38 | 3.1.1.. Мал сүргийг чанаржуулж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална. | 40.. Бэлчээрийн даацыг тогтоож, эр сувай болон үржилд тэнцэхгүй малыг оторлон таргалуулж эдийн засгийн эргэлтэнд оруулна. | 2021 - 2024 | | Сумын бэлчээрийн ургацын дундаж 0,28 ц/га гарсан. Цэнгэл баг 0,2 ц/га, Давааны ам 0,2 ц/га, Буга баг 0,4 ц/га, Хөвийн ам баг 0,6 ц/га, Пионер толгой 0,0 ц/га тус, тус гарч сумын дунджаар 0,28 цн/га ургацтай гэсэн тооцоо гарсан. Тус сумд 169667 толгой мал өвөлжих урьдчилсан дүн гарсан ба нийт малыг хонин толгойд шилжүүлснээр 333884,2 толгой мал өвөлжих төлөвлөгөөтэй байна. Нийт бэлчээрийн талбайгаар даацыг тооцож үзэхэд хүрэлцээ хангамж 41.6 хувьтай буюу 287543 хонин толгой малаар хэтрэлттэй гэсэн тооцоо гарч байна. | 100% |
| 39 | 3.1.2.. Сарлагийн сүүг уламжлалт болон орчин үеийн технологиор боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлнэ. | 41.. Сүү цагаан идээг орчин үеийн технологээр боловсруулах жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ | 2021 - 2024 | 54459000-сая | 2022 онд Улсын төсвөөс үрлэн ааруул хэвлэгч, сүү бэлтгэх тогоо, сүү ариутгагч, ааруул хатаагч, нунтаглагч тээрэм, холигч, савлагч, цөцгий цохих машин зэрэг 44495000 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Давааны ам багийн саальчин Д.Оюунцэцэг нь Сүү цагаан идээ боловсруулах төсөл бичин СХС-аас 10 сая төгрөгийн зээл авч сүү хөөрүүлдэг тогоо, ааруул хатаагч, аарц шахагч, аарц нунтаглагч, ааруул хэвлэгч зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаагаа явуулж байна. Хаяг, шошго, савлагааны асуудлыг шийдвэрлэсэн, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэн ажиллаж байна. | 90% |
| 40 | 3.1.3.. Малын үүлдэр угсааг сайжруулж, аймаг орон нутгаас барьж байгаа бодлогын хүрээнд үндсэн сайжруулагчийг ашиглаж, 1 малаас авах ашиг шимийг | 42.. Аймгаас барьж байгаа бодлогын хүрээнд баталгаажсан үүлдэр омгийн малыг үндсэн сайжруулагчаар ашиглах бодлого баримталж | 2021 - 2024 | | Баталгаажсан үүлдэр омгийн малыг сайжруулагчаар ашиглаж ашиг шимийн чиглэлээр бүсчлэн үржүүлэх бодлогыг баримтлахын зэрэгцээ байгалийн шалгарлыг даван туулж нутгийн онцлогт дасан зохицсон өөрийн нутгийн малыг өсгөн үржүүлж генфондыг нь хамгаалахад илүүтэй анхаарч байна. Хурдан удмын азарга болон монголын бухыг цөөн тооны малд сайжруулагчаар ашиглаж байна. Бог малд Баянбулаг омгийн хуц, Бөмбөгөр омгийн ухныг сайжруулагчаар ашиглаж байна. Улсын их хурлын дарга Г.Занданшатарын хэрэгжүүлж буй Малын | 100% |

| | | | | | | |
|----|---|--|-------------|---|--|------|
| | нэмэгдүүлнэ. | ажиллах. | | | чанар сайжруулах "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Сарлагийн зургаан бухан бярууг цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор Архангай аймгийн Цахир сумаас авчирсаныг мал эмнэлгийн шинжилгээ, туулга, боловсруулалтад хамруулан иргэн П.Амаржаргалаар маллуулан холбогдох сумдад хүлээлгэн өгсөн. Тус төслийн хүрээнд Баянбулаг үүлдрийн 25 хурган хуц авчиран хээлтүүлэгч мал маллагч нарт хариуцуулан маллуулж сонирхсон малчидтай түрээсийн гэрээ байгуулан хүлээлгэн өгч байна. | |
| | | | | | Хавсралт : 6 зураг | |
| 41 | 3.1.4.. "Малын эрсдэлийн сан"-г малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг усжуулах, малын тэжээлийн ургамал тариалах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг байх орчинг бүрдүүлнэ. | 43.. Бэлчээр ашигласны төлбөрийн тодорхой хувийг мал аж ахуй газар тариалан хөгжүүлэхэд зарцуулах. | 2021 - 2024 | Малын хөлийн албан татварын хөрөнгөөс 30 сая төгрөг | Малын хөлийн албан татварын орлогоос тэжээлийн ургамал тариалах 7 га талбайг хашаажуулахад 10 сая төгрөг, гүн өрмийн худаг гаргахад 20 сая төгрөг, бэлчээрийн сэг зэмийг устгахад 592000 төгрөгийг тус тус зарцуулсан. | 100% |
| | | | | | Хавсралт : 6 зураг | |
